



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2025



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СЭДЭВ: “АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 14.7 ДАХЬ
ХЭСГИЙН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮН”



Дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа
Утас: 70483413

Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677

Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Ц.Сайханжаргал

Утас: 88665099

Цахим хаяг: saikhanjargal@audit.gov.mn

Аудитор Г.Булган

Утас: 80920029

Цахим хаяг: bulgang@audit.gov.mn

АУДИТЫН КОД: ГАА-2025/20-5-ШТА-НА



+88-66-50-99



www.audit.mn



АГУУЛГА

1. Товчилсон үгийн жагсаалт.....	2
2. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	3
3. Аудитын зорилт.....	3
4. Аудитын хамрах хүрээ.....	3
5. Аудитад ашигласан арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
6. Аудитын бүрэлдэхүүн, хугацаа.....	3
7. Үндсэн мэдээлэл.....	4
8. Төрийн байгууллагууд тухайн жилийн цалингийн сангийн хуульд заасан хувийг төсвийн төсөлдөө төлөвлөж, батлуулаагүй байна.....	4
9. Аймгийн хэмжээнд 168 төрийн байгууллага нь ахмадын сангийн данс нээгээгүй байна.....	5
10. Аймгийн хэмжээнд ахмадын сангаас 57.2 сая төгрөгийн хууль, журмын дагуу зарцуулсан байна.....	5
11. Ахмадын сангийн төлөвлөлт, зарцуулалтад эрх бүхий төрийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.....	7
12. Дүгнэлт.....	8
13. Зөвлөмж.....	8
14. Тэмдэглэл.....	10

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГАА	Говь-Алтай аймаг
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Ахмадын сангийн 2024 оны төвлөрүүлэлт, зарцуулалт
Хүснэгт №2	Ахмадын сангийн 2024 оны зардлын төрөл



1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт

Ахмад настны тухай хуулийн 14.7 дахь хэсгийн хэрэгжилт, түүний үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд оршино.

3. Аудитын хамарсан хүрээ

Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулж буй төсөвт байгууллагуудыг хамруулж мэдээ, дансны хуулга, гаргасан шийдвэрүүд болон бусад баримт материалыг хамруулсан.

4. Аудитад ашигласан арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын стандарт АДБОУС 100, 400, нийцлийн аудитын стандарт АДБОУС 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”, “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг тус тус үндэслэн шалгаж, ирүүлсэн баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйлд цуглуулж тайланг бэлтгэв.

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг хэрэгжүүлж, аудитор Ц.Сайханжаргал, Г.Булган нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн.

Үндсэн мэдээлэл

Ахмад настны тухай хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Засгийн газрын 2017 оны “Ахмадын сан байгуулан ажиллах тухай”, 197 дугаар тогтоол хүчингүй болж Засгийн газрын 2024 оны өдрийн 243 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам” хэрэгжиж байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд Төрийн санд ахмадын сангийн данс нээлгэсэн 10 байгууллага байна. Үүнд:

- Говь-Алтай аймаг дахь Шүүхийн Тамгын газар
- Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар



- Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
- Говь-Алтай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
- Говь-Алтай аймгийн Татварын газар
- Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс
- Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газар
- Говь-Алтай аймгийн Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа
- Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэг

Ахмад настны тухай хуулийн дагуу аймгийн Цагдаагийн газар, Татварын газар, Шүүхийн Тамгын газар нь байгууллагын үүргээ хэрэгжүүлж ахмадад дэмжлэг үзүүлж байна.



Төсвийн байгууллагууд ахмадын сан байгуулахаар тухайн жилийн цалингийн сангийн хуульд заасан хувийг төсвийн төсөлдөө төлөвлөж, батлуулаагүй байна.

- 1.1. Ахмадын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дэх хэсэгт¹ төсөвт байгууллагууд тухайн жилийн төсөвт цалингийн сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг ахмадын сандаа төлөвлөж тусгахаар заасан.
- 1.2. Аймгийн хэмжээнд хуульд заасны дагуу ахмадын сангийн мөнгөн хөрөнгийг төлөвлөж, батлуулсан төсөвт байгууллага байхгүй байна.
- 1.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 178 төсөвт байгууллагын 2024 оны цалингийн нийт сан 128,785.6 сая төгрөг байна. Үүний гурав хувиар ахмадын сан байгуулахад 3,863.5 сая төгрөгийг ахмад настнуудад Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дэх хэсэгт² тусгагдсан тэтгэмж, хүндэтгэл хүртэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдах, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх боломжтой байсан байна.

Аймгийн хэмжээнд 168 төсөвт байгууллага Төрийн санд ахмадын сангийн данс нээгээгүй байна.

- 1.4. Аймгийн хэмжээнд төсөвт 178 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 10 байгууллага ахмадын сангийн данс нээлгэж, 168 байгууллага данс нээлгээгүй байна.
- 1.5. Данс нээлгэсэн 10 байгууллагаас аймгийн Цагдаагийн газар, Татварын газар, Шүүхийн Тамгын газрууд нь хуулийн дагуу ахмадын сан байгуулж ахмадуудад дэмжлэг үзүүлжээ.
- 1.6. Говь-Алтай аймгийн Прокурорын газар, Онцгой байдлын газар, Бургастай дахь Гаалийн хороо зэрэг байгууллагуудын ахмад сан нь дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд төвлөрүүлж, зарцуулж байна.

¹ 14.7.Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.

² 14.6.Аж ахуйн нэгж, байгууллага нь ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хүндэтгэл үзүүлэх, нийгэм, соёл, урлаг, аялал, биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ.



Ахмадын сан байгуулсан 3 байгууллага 2024 онд 57.2 сая төгрөгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.

2.1. Ахмадын сангийн дансанд 2024 онд 67.1 сая төгрөгийг 4 байгууллага эхний үлдэгдлээс, 110.3 сая төгрөгийг 5 байгууллага тайлант онд журмын дагуу татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №1: Ахмадын сангийн 2024 оны төвлөрүүлэлт, зарцуулалт

(сая.төгрөг)

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зарцуулсан мөнгөн дүн	Эцсийн үлдэгдэл
1	Цагдаагийн газар	21.8	47.2	19.8	49.2
2	Татварын газар	34.0	47.0	29.0	52.0
3	Шүүхийн Тамгын газар	11.3	0	8.3	3.0
4	Нийгмийн даатгалын газар	0,005	0	0	0,005
5	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын хамгаалалтын захиргаа	0	5.6	0	5.6
6	Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэг	0	10.1	0	10.1
7	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	0	0.4	0	0.4
Нийт		67.1	110.3	57.2	120.3

Эх сурвалж: Ажлын баримтаас.

2.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нэгдсэн эмнэлэг, Стандарт, хэмжил зүйн газар нь 2025 онд данс нээсэн байна.

2.3. Ахмадын сан байгуулсан аймгийн Цагдаагийн газар 19.8 сая төгрөг, Татварын газар нь 29.0 сая төгрөг, Шүүхийн тамгын газар 8.3 сая төгрөгийг 2024 онд тус тус хуулийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулжээ.

Хүснэгт №2: Ахмадын сангийн 2024 оны зардлын төрөл

(сая.төгрөг)

№	Зардлын төрөл	Зарцуулсан мөнгөн дүн
1	Байгууллага, салбартаа онцгой үр бүтээл гарган олон жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох;	11.1
2	Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах;	19.5
3	Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад зориулан мөнгөн дэмжлэг үзүүлэх;	3.6
4	Хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;	1.0



5	Шинээр хашаа, байшин барих, засварлах, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулахад зориулж ахмад настанд дэмжлэг үзүүлэх;	0.5
6	Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд зориулж мөнгөн тусламж үзүүлэх;	10.7
7	Ахмад настан өөрөө эсхүл, түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох;	4.9
8	Ахмадуудын дунд идэвхтэй насжилтыг дэмжих амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	1.4
9	Хуульд заасан хүрээнд ахмад настанд чиглэсэн бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх.	4.5
Нийт		57.2

2.4. Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын газар нь дээд шатны төсөв захирагчийн шилжүүлсэн ахмадын сангийн мөнгөн хөрөнгийг байгууллагын нярвын дансанд шилжүүлэн зарцуулж байна.

Ахмадын сангийн төлөвлөлт, зарцуулалтад эрх бүхий төрийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.5. Говь-Алтай аймгийн Төрийн аудитын байгууллага нь жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар ахмадын сангийн орлого, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байна.

2.6. Аудитын хүрээнд Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын хамгаалалтын захиргаа, Есөнбулаг сумын 11 дүгээр цэцэрлэг нь төслийн төсөлд тусгаагүй, дээд шатны төсөв захирагчаас зөвшөөрөл аваагүй ахмадын сан байгуулсан зөрчилд 2 шийдвэр өгч шийдвэрийн хэрэгжилтийг хангуулсан байна.

2.7. Аймгийн Засаг дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Ахмадын сангийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн төсвийн байгууллагуудын холбогдох баримт материалуудыг хянаж, дүнг нэгтгэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд тухайн жилийн цалингийн сангийн хуульд заасан хувийг төсвийн төсөлдөө төлөвлөж, батлуулаагүй байна.
- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 168 төрийн байгууллага нь ахмадын сангийн данс нээгээгүй байна.
- Нийгмийн даатгалын газар нь дээд шатны төсөв захирагчийн шилжүүлсэн ахмадын сангийн мөнгөн хөрөнгийг байгууллагын нярвын дансанд шилжүүлэн зарцуулж байна.



- Ахмадын сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдүүд нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Говь-Алтай аймгийн Засаг даргад

- Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагууд тухайн жилийн цалингийн сангийн хуульд заасан хувийг төсвийн төсөлдөө төлөвлөж, батлуулах арга хэмжээг авч ажиллах.
- Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудад ахмадын сангийн данс нээлгэж хуулийн хэрэгжилтийг хангуулах.

Говь-Алтай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт

- Төрийн байгууллагууд ахмадын сангийн данс нээгээгүй байгаа асуудалд хяналт хэрэгжүүлэн хуулийн хэрэгжилтийг хангуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Говь-Алтай аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст

- Аймгийн Нийгмийн даатгалын газар нь дээд шатны төсөв захирагчийн шилжүүлсэн ахмадын сангийн мөнгөн хөрөнгийг хувь иргэний дансаар дамжуулан гүйлгээ хийж буй асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас/Факс: 7048-4042, Цахим шуудан: info@govi-altai.gov.mn
Цахим хуудас: www.gov-altai.gov.mn

2025. 10. 03 № 3/1347
танай 2025. 09. 30 -ны № 543 -Т

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас ирсэн “Ахмад настны тухай хуулийн 14.7 дах хэсгийн хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөл, асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Тайлангийн төсөл, асуудлын бүртгэлтэй холбоотой санал байхгүй болно.

ДАРГА  Ш.ЭРДЭНЭБАТ



D:Ajil.heltses TD/A5

851800001/06

